

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ТЭРГҮҮЛЭГЧИД ТҮҮНИЙ АЖЛЫН АЛБАНААС 2017 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН  
АЖЛЫН ТАЙЛАН**

2017 оны 12 дугаар сарын 15

Улаанбаатар хот

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Хүний хөгжилд тулгуурласан, Төр иргэний хамтын ажиллагаанд суурилсан, нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр дүүргийн нийгэм, эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангасан нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг бэхжүүлэх зорилго тавьж, үйл ажиллагаандаа ил тод, нээлттэй, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, хууль дээдлэх зарчим баримтлан ажиллалаа.

**НЭГ. “ХУРЛЫН БОДЛОГЫН ЗОРИЛТ- ХЭРЭГЖИЛТ”**

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчид түүний Ажлын албанаас Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагааг иргэдэд ойртуулж, Хурлын байгууллагын ил тод, нээлттэй, шуурхай байдлыг хангах, хороодын Иргэдийн Нийтийн Хурлын хөгжлийг дэмжих, Хурлын Төлөөлөгчдийн идэвх санаачилгыг дэмжин, Төлөөлөгч иргэдийн хамтын ажиллагааг дээшлүүлэх зорилтыг дэвшүүлэн бодлого, үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаар Хурал нь төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хуулиар харьяалуулснаас бусад тухайн нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн аливаа асуудлыг бие даан шийдвэрлэх онцгой эрхтэй байхаар заасан байдаг билээ.

Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан бөгөөд тайлангийн хугацаанд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 3, 4 дүгээр хуралдааныг зохион байгуулж, дүүргийн 2016 оны төсвийн гүйцэтгэлийг батлах, 2017 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, дүүргийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтын хэрэгжилт дүгнэх тухай, 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай асуудлуудыг тус тус хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

Хурлын чөлөөт цагт бүрэн эрхийг нь хэрэгжүүлдэг Хурлын Тэргүүлэгчид нийт 20 удаа хуралдаж, дүүргийн өмнө тулгамдаж буй нийгэм, эдийн засгийн асуудлуудыг дүүргийн хэмжээнд хэрэгжүүлэх бодлогын баримт бичгийг батлан гаргаж, түүний хэрэгжилтэд хяналт тавих үүргийг хэрэгжүүлэн ажиллалаа.

Хурлын Тэргүүлэгчид 2017 онд хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд тусгагдсан Хөтөлбөр, төсөл арга хэмжээний чиглэлээр 20, Хяналт шалгалтын ажлын чиглэлээр 24, бусад ажлын чиглэлээр 14 нийт 58 асуудал хэлэлцэхээр төлөвлөснөөс 89 асуудлыг хэлэлцэн, 67 тогтоол шийдвэрийг баталсан ба цаг үеийн болон бусад асуудлаар төлөвлөгөөнд тусгагдаагүй 22 асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргасан байна. Хурлын Тэргүүлэгчдээс баталсан шийдвэрийг ангилвал:

- Удирдлага, зохион байгуулалтын чиглэлийн-16
- Хөтөлбөр, төсөл, арга хэмжээний чиглэлийн-10
- Төсөв, санхүүгийн чиглэлийн-5
- Шагнал, урамшууллын чиглэлээр-31
- Дүрэм, журам-5

Хурлын Тэргүүлэгчид хэлэлцсэн асуудлын чиглэлээр нийт 28 заалт бүхий үүрэг чиглэлийг Хурлын Ажлын албанд, 18 заалт бүхий үүрэг чиглэлийг дүүргийн Засаг дарга түүний Тамгын газарт өгсөн байна.

Хурлын Тэргүүлэгчдээс баталсан тогтоолын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхэд 100 хувь буюу бүрэн хангалттай биелэгдсэн-65, 80 хувь буюу хангалттай биелэгдсэн-2 байна.

Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлын дийлэнх нь дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны чиглэл, хөтөлбөрт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн асуудлуудыг цаг алдалгүй шуурхай шийдвэрлэхэд чиглэгдсэн байна.

**Хурлын Тэргүүлэгчид 2017 онд удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:**

- Дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл
- Хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах дэд зөвлөл
- Хороодын нутаг дэвсгэрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг удирдан зохион байгуулах баг
- Дүүргийн 2017 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилттэй танилцах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар холбогдох арга хэмжээ авах, зуслангийн ногоон бүсэд иргэн, хуулийн этгээдэд шинээр эзэмшүүлэх газрын байршил, хэмжээг шинэчлэн тогтоох, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, дүгнэлт боловсруулах ажлын хэсэг
- Дүүргийн 25 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсгийг тус тус шинэчлэн болон шинээр байгуулж
- Хурлын Ажлын албаны хөдөлмөрийн дотоод журам
- Хороодын Иргэдийн Нийтийн Хурлын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх журам
- Дүүргийн ГХУСАЗЗ-ийн ажиллах журам
- Хороодын нутаг дэвсгэрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг удирдан зохион байгуулах багийн ажиллах журам
- Хороодод ажиллах хэв журмын урамшилт эргүүлийн ажиллах журам
- Хороодын гудамж, байранд нийтийн эргүүл ажиллуулах журам
- Иргэний танхимын ажиллах журам
- Иргэдийн хяналтын зөвлөлийн ажиллах журамыг тус тус шинээр болон шинэчлэн баталлаа.

**Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцсэн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгээс дурдвал:**

- Ногоон дүүрэг хөтөлбөр
- Чингэлтэйд үйлдвэрлэв хөтөлбөр
- Эрүүл мэнд 2020 хөтөлбөр
- Жаргалтай гэр бүл хөтөлбөр
- Хотын иргэн-хотын соёл хөтөлбөр
- Хамтдаа хөгжье хөтөлбөр
- Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр
- Чингэлтэй боловсрол хөтөлбөр
- Гамшгаас хамгаалах сайн дурын үйл ажиллагааг дүүргийн хэмжээнд зохион байгуулах гамшиг осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр
- Иргэдийн оролцоотой хяналттай орчин хөтөлбөр

**Хяналт шалгалт, эрчимжүүлэх арга хэмжээний чиглэлээр:**

- Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн үйл ажиллагаа, цаашдын зорилт
- Дүүргийн 2016 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын дүн, орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтын талаар хийж хэрэгжүүлж буй үйл ажиллагаа
- Нийслэл, дүүргийн төсвөөр 2017 онд хэрэгжих хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний бэлтгэл ажил
- Дүүргийн Татварын хэлтсийн үйл ажиллагаа, татварын төлөвлөгөөний биелэлт
- Дүүргийн 2017 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт
- Хурлын Ажлын албаны 2017 оны эхний хагас жилийн ажлын тайлан
- Хурал, Тэргүүлэгчдийн тогтоол, шийдвэрийн биелэлт
- Хурал, Тэргүүлэгчдэд иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал
  - Батлагдсан хөтөлбөрүүдийн хэрэгжилттэй тус тус танилцаж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар үүрэг чиглэл өгч ажиллалаа.

Дүүргийн Засаг дарга түүний Тамгын газраас Хурлын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэхээр нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдөх бодлогын 10, зохион байгуулалтын 3, хяналт шалгалтын 20, байгууллага иргэдэд хандсан 16, нийт 49 баримт бичгийн төслийг боловсруулж Хурал, Тэргүүлэгчдээр батлуулсан байна.

Хурал, Тэргүүлэгчдээс 2017 онд хяналт шалгалтын ажлын чиглэлээр Хурлын хороодоос зохион байгуулах ажил, хэлэлцэх асуудлын сэдэвчилсэн төлөвлөгөөг оны эхэнд батлан, Хурлын хороод 57 ажил зохион байгуулахаас 53 ажил бүрэн хийгдэж, биелэлт 92,9 хувьтай байна.

Хурлын даргын баталсан удирдамжийн дагуу Хурлын хороод нийт 37 удаа хуралдсанаас; Эрх зүй, нутгийн удирдлагын хороо 6, Ногоон хөгжил, газрын харилцааны хороо 5, Хот байгуулалт, үйлдвэрлэл үйлчилгээ, гэр хороололын хөгжлийн хороо 8, Нийгмийн хөгжлийн хороо 7, Ёс зүй, өргөдлийн хороо 3, Төсвийн зарцуулалтын хяналтын хороо 5, Эдийн засаг, төсвийн хороо 3 удаа тус тус

хуралдаж, танилцсан ажлын чиглэлээр санал дүгнэлт боловсруулан Хурал, Тэргүүлэгчдэд танилцуулсан байна.

Хурлын хороод хяналт шалгалтын чиглэлээр дараах байгууллагуудын үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй ажлуудын явц байдал, гүйцэтгэлтэй танилцсан байна. Үүнд:

**Эрх зүй, нутгийн удирдлагын хороо:**

- Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн төсөл, хэрэгжилт
- Гамшгаас хамгаалах сайн дурын үйл ажиллагааг дүүргийн хэмжээнд зохион байгуулах гамшиг осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн төсөл, хэрэгжилт
- Иргэдийн хяналтын зөвлөлийн ажиллах журмын төсөл
- Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтэс, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хамтын ажиллагааны хэлтэс, Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Хүүхдийн номын өргөө ОНӨААНҮГ, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс, Замын цагдаагийн хэлтсийн үйл ажиллагаатай танилцах
- Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн зорилтын “Жаргалтай иргэн-Нутгийн удирдлагын хөгжил” бүлгийн хэрэгжилт, дүүргийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл

**Ногоон хөгжил, газрын харилцааны хороо:**

- Ногоон дүүрэг хөтөлбөрийн төсөл, хэрэгжилт
- Хороодын газрын зөрчил
- Хороодын хилийн цэсийг тэмдэг, тэмдэглэгээтэй болгох ажлын бэлтгэл ажилтай танилцах
- Чингэлтэй хайрханы “Эрдмийн цэцэрлэгт хүрээлэн”-гийн тохижилтын ажилтай газар дээр нь танилцан, хяналт тавих
- Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн “Жаргалтай орчин-Ногоон хөгжил” бүлгийн зорилтуудын хэрэгжилтийг дүгнэн, Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл

**Нийгмийн хөгжлийн хороо:**

- Эрүүл мэнд 2020 хөтөлбөрийн төсөл, хэрэгжилт
- Жаргалтай гэр бүл хөтөлбөрийн төсөл, хэрэгжилт
- Хамтдаа хөгжье хөтөлбөрийн төсөл, хэрэгжилт
- Чингэлтэй боловсрол хөтөлбөрийн төсөл, хэрэгжилт
- Хөдөлмөр халамж, үйлчилгээн, Нийгмийн даатгалын хэлтэс, дүүргийн 1-19 дүгээр хорооны Өрхийн эрүүл мэндийн төв, Эмнэлэгийн хөдөлмөр магадлах комисс

- Дүүргийн 2017 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай асуудал /харъяалах асуудлаар/
- Ерөнхий боловсролын сургуулиудын үйл ажиллагаа
- Ерөнхий боловсролын 140 дүгээр сургууль, 222, 174 дүгээр цэцэрлэг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн үйл ажиллагаа
- Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтын хэрэгжилт, дүүргийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл

**Ёс зүй өргөдлийн хороо:**

- Иргэний танхимын ажиллах журмын төсөл
- Хороодын Иргэний танхимын үйл ажиллагаатай танилцах
- Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих
- Санал асуулга, олон нийтийн санал бодлын тандалт судалгаа явуулах, үр дүнгийн талаар мэдээлэл өгөх
- Иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавих
- Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтын хэрэгжилт, дүүргийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл

**Хот байгуулалт, үйлдвэрлэл үйлчилгээ, гэр хорооллын хөгжлийн хороо:**

- Чингэлтэйд үйлдвэрлэв хөтөлбөрийн төсөл, хэрэгжилт
- Хамтдаа хөгжье хөтөлбөрийн төсөл, хэрэгжилт
- Тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс, Чингэлтэй тохижилт үйлчилгээний компани, Соён дрийм ХХК, Наашаа трейд ХХК,
- Нийслэл дүүргүүдийн хот байгуулалт үйлдвэр, үйлчилгээ, гэр хорооллын хөгжлийн чиглэлийн Хурлын хороодын үйл ажиллагаатай танилцах
- Нийслэлд 2017 онд хот байгуулалт, үйлдвэр, үйлчилгээ, гэр хорооллын хөгжлийн чиглэлээр хэрэгжих хөтөлбөр, төсөл арга хэмжээ
- Дүүргийн 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний хэрэгжилт
- Хорооны нэрэмжит “Нээлттэй хаалганы өдөрлөг” арга хэмжээ
- Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтын хэрэгжилт, дүүргийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл

**Эдийн засаг, төсвийн хороо:**

- Чингэлтэйд үйлдвэрлэв хөтөлбөрийн төсөл, хэрэгжилт
- Татварын хэлтэс, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагаа
- Дүүргийн 2017 оны төсөв өөрчлөлт оруулах тухай асуудал /харъяалах асуудлаар/

- Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтын хэрэгжилт, дүүргийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл

#### **Төсвийн зарцуулалтын хяналтын хороо**

- Дүүргийн Засаг даргын 2017 оны батлагдсан төсвийн хуваарьтай танилцах
- Дүүргийн ЗДТГ-ын гадаад арга хэмжээний төлөвлөгөө, төсөлтэй танилцах
- Дүүргийн 2016 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын дүн, орон нутгийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт
- Дүүргийн 2016 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай асуудал /харьяалах асуудлаар/
- “Чингэлтэй ахмадын амралт” ОНӨААТҮГ, “Ногоон булан” дүүргийн ахмадын амралт сувилал” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа
- Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтын хэрэгжилт, дүүргийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл

#### **ХОЁР. ”ХУРЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТӨВЛӨРСӨН АРГА ХЭМЖЭЭ”**

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас дэвшүүлсэн зорилт, Хурлын байгууллагын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Тэргүүлэгчдээс баталсан төлөвлөгөөний дагуу иргэд рүү чиглэсэн, бүтээлч, үр дүн бүхий төвлөрсөн арга хэмжээнүүдийг зохион байгуулан ажиллахыг зорилоо.

Хурлын Тэргүүлэгчид, Ажлын албанаас зохион байгуулсан ажлаас дурдвал:

Монгол Улсад Ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан Үндсэн хууль батлалцсан Чингэлтэй дүүргийн харьяат, тухайн үеийн АИХ-ын депутатуудыг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээнд АИХ-ын депутатаар ажиллаж байсан Чингэлтэй дүүргийн харьяат Л.Дашням, Г.Дэндэв, Д.Мандах, М.Шийрав, Н.Гаравсүрэн нар оролцлоо.

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 39 дүгээр тогтоол, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 55 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төслийн талаар иргэдээс санал авах хэлэлцүүлгийг дүүргийн хэмжээнд зохион байгууллаа. Тус хэлэлцүүлэгт 1651 иргэн оролцсон бөгөөд хэлэлцүүлгийн үеэр 288 иргэн амаар, саналын хуудсаар 1127 санал ирүүлсэн байна. Мөн дүүргийн 1-19 хорооны 16279 иргэн саналын хуудсаар санал ирүүлж, уг саналыг цахим программд нэгтгэх ажлын хэсэгт хороодын Иргэний танхимын ажилтнууд ажиллаж, саналын хуудсыг архивлаж холбогдох байгууллагад хүлээлгэн өгөх ажлыг зохион байгууллаа.

Тайлант хугацаанд нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ирүүлсэн удирдамжийн хүрээнд Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсан өдрийг угтаж дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нэрэмжит шатар сонирхогчдын “Дүүргийн аварга” шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, тэмцээнээс

шалгарсан эрэгтэй 6, эмэгтэй 3 шилдэг шатарчдыг Нийслэлийн шатар сонирхогчдын аварга шалгаруулах тэмцээнд оролцуулав.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Ажлын алба, Хурлын Төлөөлөгчдийн ажиллах нөхцөл бололцоог нь хангаж, дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлэхэд нь тусалж, тэдний үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг төсөвт тусгуулах, тухайн жилд хийгдэх дүүргийн нийгэм, эдийн засгийн зорилт, төсөв төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх талаар анхаарч ажиллалаа.

Иргэдийн Хурлын Төлөөлөгчдийн үйл ажиллагааг дэмжих, Хурлын Төлөөлөгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор УИХ-ын Тамгын газар, Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн “Монгол Улс дахь төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь төсөл”-тэй хамтран “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийг чадавхжуулах нь” Үндэсний суурь сургалтыг 2 өдөр зохион байгуулж, “Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн үндэс, үйл ажиллагаа”, “Орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө, төсөв, эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт”, “Байгаль хамгаалал, газрын харилцаа”, “Иргэдийн оролцоо, ба иргэдтэй харилцах нь” сэдвийн хүрээнд, мөн Тиймворк тимплей сургалтын төвтэй хамтран “Манлайлал-Иргэний оролцоо” сургалтыг зохион байгуулсан бөгөөд “Багаар ажиллах, үр нөлөөтэй баг бүрдүүлэх”, “Төрийн бодлого шийдвэрт иргэдийн оролцоог хангах”, “Төлөөлөгчдийн манлайлал, манлайлагчийн хөгжил” зэрэг сэдвийн хүрээнд амжилттай зохион байгууллаа.

Иргэд-Төлөөлөгчийн хамтын ажиллагааны хүрээнд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан удирдамжийн хүрээнд “Иргэдээ сонсьё” 1 сарын аяныг дүүргийн хэмжээнд зохион байгууллаа. Нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдөөс хийж хэрэгжүүлсэн ажлыг сурталчилан таниулах, иргэдэд тулгамдаж буй асуудлыг судлан шийдвэрлэх, иргэдийн санал санаачилгыг бодлого, шийдвэртээ тусган хэрэгжүүлэх зорилготой тус аянд дүүргийн нийт 1769 иргэн хамрагдаж, иргэдээс ирүүлсэн 1444 санал хүсэлтийг салбар бүрээр нь ангилан, дүн шинжилгээ хийж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулан, дүүргийн Засаг даргын Тамгын газар, холбогдох байгууллага, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэн ажиллалаа.

Жил бүрийн 4 дүгээр сарыг “Эрүүл мэндээ хамгаалах сар”-ын аян болгон зарладаг уламжлалын дагуу тус сарын аяны хүрээнд эрүүл мэндийн чиглэлийн сургалт, өдөрлөг, уулзалт ярилцлага, үзлэг оношлогоо, зөвлөгөө, мэдээлэл зэрэг олон хэлбэр бүхий арга хэмжээг дүүргийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төв, хороодын Засаг даргын Ажлын алба, Өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран зохион байгууллаа.

Тус арга хэмжээний хүрээнд иргэдийн халдварт бус өвчнийг эрт илрүүлэх үзлэг, бэлгийн замын халдварт өвчин, элэгний В, С вирусны шинжилгээнд хамруулж, урьдчилан сэргийлэх, хэвтрийн өвчтэй ахмад болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд гэрийн эргэлт сувилахуйн үйлчилгээ үзүүлэх, нөхөн

үржихүйн насны эмэгтэйчүүдэд чиглэсэн мэдлэг мэдээлэл олгох сургалт зэрэг 3 үе шаттайгаар зохион байгууллаа.

Аяны хүрээнд Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтад 544 иргэн, “Иргэн танд туслая” үйл ажиллагаанд 44 иргэн, Сайн хяналтаас Эрүүл эх-Эрүүл хүүхэд сургалтад 388 иргэн, эмэгтэйчүүдийн анхан шатны үзлэгт 271 иргэн, нийт 1247 дүүргийн иргэн хамрагдсан байна.

Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Хурал дахь намын бүлгийн ажлын албаны ажилтан, албан хаагчдын 0-16 насны манлайлагч хүүхдүүдийг хүлээн авч, “Хүүхдийн эрх” сэдэвт гар зургийн уралдаан зохион байгуулж, гарын бэлэг гардуулж, нийт 53 хүүхэд багачууд оролцсон байна.

“Хүүхдийг зодож, шийтгэхгүй байх” Олон Улсын өдрийг тохиолдуулан хүүхдийн бие махбодь, сэтгэл санааны эсрэг шийтгэлийг таслан зогсоох, тэдний эрхийг хамгаалах, эцэг, эх, асран хамгаалагч нарт хүүхэд хүмүүжлийн эерэг аргуудыг сурталчилах зорилго бүхий “Хүүхдийн эрхийг дээдэлж, гэр бүлийн хүчирхийллийг зогсооцгооё” өдөрлөгийг зохион байгууллаа. Уг арга хэмжээнд дүүргийн хүүхэд багачууд, эцэг, эхийн төлөөлөл, хүүхэдтэй ажилладаг байгууллага, хамт олон, нийгмийн ажилтнууд оролцлоо.

Дүүргийн 25 жилийн ой, Дэлхийн “Гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулан Хурлын Тэргүүлэгчид, Ажлын албанаас санаачилан 5 дугаар сарыг “Гэр бүлийн сар”-ын аян болгон зарлаж, аяны хүрээнд “Миний гэр бүл” сэдэвт арга хэмжээг хороодын Иргэний танхимаар дамжуулан зохион байгууллаа. Уг арга хэмжээнд 1-19 дүгээр хороодын 128 гэр бүлийн 384 эцэг, эх, хүүхдүүд оролцсоноос гадна Хурлын Төлөөлөгч, хороодын Иргэдийн Нийтийн Хурлын дарга, Засаг дарга, Хурлын Ажлын албаны ажилтан, алба хаагчид оролцлоо.

Монгол Улсад шинээр батлагдсан хууль, тогтоомжийн талаар иргэдэд мэдлэг олгох зорилгоор Монголын мэтгэлцээний Нэгдсэн Нийгэмлэгтэй хамтран “Эрх зүйн боловсрол-Иргэний хөгжил” сэдэвт сургалтыг зохион байгуулж, сургалтад нийт 1000 гаруй иргэн хамрагдаж, хууль тогтоомжийн талаарх мэдлэг, мэдээллээ дээшлүүлсэн байна.

Дүүргийн хөгжилд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, тэдний санал санаачилгыг дэмжих зорилго бүхий Залуучуудын хөгжлийг дэмжих сарын аяны хүрээнд “Хоймор дүүргийн-Хийморьлог залуус” үйл ажиллагааг Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд хөгжлийн газар, дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Teamwork and Teamplay Mongolia сургалтын төвтэй хамтран зохион байгуулж, хороодын 91 залуучууд хамрагдсан байна.

Түүнчлэн иргэдэд хууль сурталчлах ажлыг хүрээнд дүүргийн Прокурорын газартай хамтран иргэдэд Монгол улсын Зөрчлийн тухай хуулийн талаарх мэдлэг олгох, гэмт хэрэг, зөрчлийн талаарх ойлголтыг өгөх, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчилд тооцох, урьдчилан сэргийлэх талаар



мэдээ, мэдээлэл олгох үйл ажиллагааг дүүргийн хэмжээнд зохион байгуулж, сургалтад хороодын ИНХ-ын дарга, Засаг дарга болон хороодын 748 иргэн хамрагдсан байна.

Сургалтын үеэр иргэд Зөрчлийн тухай хуулийн иргэнд хамааралтай заалтаар тусгайлан гарын авлага боловсруулан 2000 ширхэгийг хэвлэн тарааж ажилласан бөгөөд иргэд өөрсдийн тулгамдаж буй асуулаар асуулт асууж, саналаа илэрхийлж, тухай бүрт нь хуулийн хүрээнд мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулав.

Олон Улсын Ахмадын өдрийг тохиолдуулан “Ахмад настанд ээлтэй байгууллага, иргэн шалгаруулах журам”-ын хүрээнд дүүргийн Ахмадын хороо, Хурлын Ажлын албаны хамтарсан бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдаж ахмадын байгууллагаас зохион байгуулж буй ажилд идэвх санаачилгатай оролцож, ахмад настны төлөө чин сэтгэлээсээ хандаж дэмжлэг тусламжаа үзүүлсэн Чингэлтэй дүүргийн 1, 10, 18 дугаар хорооны 3 аж ахуйн нэгж байгууллагыг “Ахмад настанд ээлтэй байгууллага”-аар, эд материалын тусламж үзүүлсэн 5, 6, 17 дугаар хорооны 3 иргэнийг “Ахмад настанд ээлтэй иргэн”-ээр тус тус шалгаруулж шагнаж урамшуулсан байна.

Түүнчлэн Ахмад настны тухай хуулийг сурталчилан таниулах, ахмад настуудыг нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах зорилгоор Хурлын Тэргүүлэгчдээс “Ахмадаа хүндэтгэе” үйл ажиллагааг Нийслэлийн Нийгмийн халамжийн газар, дүүргийн Соёлын төвтэй хамтран зохион байгуулж, “Халамжийн үйлчилгээг танд” нэртэй гарын авлагыг тарааж, үйл ажиллагаанд оролцсон ахмадуудаас Нийслэлийн Нийгмийн халамжийн газрын удирдлагуудад хандаж 13 ахмад настан санал, хүсэлтээ илэрхийлснийг уламжиллаа. Тус үйл ажиллагаанд 19 хорооны ахмадын төлөөлөл болох 116 ахмад хамрагдсан байна.

Агаарын бохирдол, хүлэмжийн хийг бууруулах, гэр хорооллын айл өрхүүдийн эрчим хүчний хэрэглээг багасгах, шингэрүүлсэн нефтийн хийн ерөнхий ойлголт өгөх, шингэн хийн газрын зөв хэрэглээ, аюулгүй ажиллагааны талаарх анхан шатны мэдлэг, мэдээллийг олгох, халаалтын тоног төхөөрөмжийг хөнгөлөлттэй үнээр нийлүүлэх, танилцуулах зорилгоор “Юнигаз” ХХК хамтран 7-19 хорооны айл, өрхийг хамруулан 7, 12, 16, 17, 19 дүгээр хорооны Иргэний танхимд сургалт, үйл ажиллагааг амжилттай зохион байгууллаа.

Нутгийн өөрөө удирдах байгууллага бол иргэд олон түмнээсээ сонгогддог, иргэдийнхээ нийтлэг эрх ашгийн төлөө ажилладаг байгууллага, өөрөөр хэлбэл Хурлын ажлын гол цөм бол Иргэд юм.

Иргэдэд хууль тогтоомжийг сурталчилан таниулах, хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор “Хуулийн мэдлэгээ хамтдаа дээшлүүлцгээе” аяныг Иргэний танхимаар зохион байгууллаа. Уг үйл ажиллагааны хүрээнд хороодын Иргэний танхимаар нийт 48 хууль сурталчилах сургалт, үйл ажиллагаа зохион байгуулагдсанаас гэмт хэрэг зөрчлийн чиглэлээр 25, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах чиглэлээр 14, онцгой байдал, аюулгүй ажиллагааны чиглэлээр 2, санхүү, эдийн засгийн чиглэлээр 1, эрүүл ахуйн чиглэлээр 1, нийгмийн хамгаалалын чиглэлээр 4 сургалтуудыг зохион байгуулж, Хууль зүйн зөвлөгөө,

эрх зүйн туслалцаа үйлчилгээ үзүүлэх 2 үйл ажиллагаа, танин мэдэхүйн чиглэлээр 1 үйл ажиллагаа зохион байгуулагдаж давхардсан тоогоор 1551 иргэн хамрагдаж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлсэн байна.

Тус аяны хүрээнд хурлын Төлөөлөгчдийн сонгогдсон тойрогтоо ажиллах, Төлөөлөгч-Иргэдийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор 12 төлөөлөгч сургалтын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, иргэдэд мэдээлэл өгч, тойрогтоо ажиллалаа.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсэдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг тохиолдуулан Чингэлтэй дүүргийн харьяат улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсэд, тэдний гэр бүл, үр хүүхдүүдэд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг Түвдэнпэлжээлин хийдтэй хамтран зохион байгуулж, хэлмэгдэгсдийн хойдын буянд зориулж буяны ном хуруулж, хүндэтгэл үзүүлэн, гарын бэлэг гардууллаа. Тус үйл ажиллагаанд улс төрийн хилс хэрэгт өөрөө хэлмэгдсэн 4 иргэн, хэлмэгдэгсдийн үр хүүхэд, тэдний гэр бүл нийт 84 иргэн оролцлоо.

2017 онд Чингэлтэй дүүрэг маань гал голомтоо бадраан, их хотын хойморт хайрхан уулаараа овоглосны 25, НӨУЁБ-ын 25 жилийн ой тохиосон онцлогтой жил байлаа.

Ойн хүрээнд 1992 оноос хойш дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд ажиллаж байсан үе үеийн дарга, Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, Төрийн албан хаагчдад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгууллаа.

Нийслэлийн 378 жилийн ой, Чингэлтэй дүүрэг үүсэн байгуулагдсаны 25 жилийн ой, эрүүл мэндийг дэмжих жилийн хүрээнд дүүргийн Засаг даргын нэрэмжит “Спорт наадам-2017” тэмцээн, мөн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас уламжлал болгон зохион байгуулагддаг “Хангарди-2017” спорт наадмуудад Хурлын Төлөөлөгч, Хурлын Ажлын албаны ажилтан, албан хаагчдын бүрэлдэхүүнтэй баг, тамирчид спортын 5 төрөлд өрсөлдсөнөөс “Нисдэг таваг” төрөлд Хоёрдугаар байр, Сагсан бөмбөгийн төрөлд эрэгтэй баг Гуравдугаар байрт тус тус шалгарч амжилттай оролцлоо.

Монгол Улсын биеийн тамир спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд зохион байгуулагдсан “Улаанбаатар марафонд нэгдэцгээе” цом аялуулах аяны хүрээнд Хурлын Ажлын алба, Хурал дахь намын бүлгийн ажлын албаны ажилтан, албан хаагчдын дунд Дартсын тэмцээнийг амжилттай зохион байгуулж, “Улаанбаатар марафон-2017” Олон Улсын Марафонд байгууллага хамт олны төлөөлөл амжилттай оролцлоо.

### **ГУРАВ. “ХОРООНЫ ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРАЛ, ИРГЭНИЙ ТАНХИМЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА”**

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын томоохон нэг зорилт бол анхан шатны Хурлын байгууллагыг бэхжүүлэх, чадавхжуулах явдал юм.

Хороодын Иргэдийн Нийтийн Хурлын үйл ажиллагааг чадавхжуулах, хамтран ажиллах замаар нутгийн өөрөө удирдах ёсыг анхан шатны нэгжид төлөвшүүлэх зорилтын хүрээнд Хороодын Иргэдийн Нийтийн Хурлын үйл ажиллагааг тогтмолжуулах, Хурлын дарга нарын ажлын уялдаа холбоог сайжруулах, харилцан мэдээ, мэдээлэл солилцох, тэднийг сургалт арга зүйгээр хангах зорилгоор Хороодын Иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчдийн зөвлөлдөх уулзалтыг 1 удаа, Хорооны Иргэдийн Нийтийн Хурлын үйл ажиллагааг чадавхжуулах ажлын хүрээнд нийт 3 удаагийн сургалт, арга хэмжээг зохион байгуулсан ба Хороодын Иргэдийн Нийтийн Хурал зохион байгуулахтай холбогдуулан хороодын Иргэдийн Нийтийн Хурлын дарга нарыг арга зүйн “Зөвлөмж” гарын авлагаар хангаж ажиллалаа.

Нутгийн өөрөө удирдах байгууллагыг бэхжүүлэх, Хороодын Иргэдийн Нийтийн Хурлын үйл ажиллагаа идэвхжүүлэх, үр дүн, хамтын ажиллагааг дээшлүүлэх зорилгоор Иргэдийн Нийтийн Хурлыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулж хороодын Иргэдийн Нийтийн Хурлын дарга нар оролцож, сургалтаар Үндсэн хуулийн эрх зүй, ойлголт, мөн чанар, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Иргэдийн Нийтийн Хурлын эрх, үүрэг, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны хөтөлбөр, НӨУБ-ын эрх зүйн үндэс, чиг хандлагад гарч буй өөрчлөлтүүд зэрэг сэдвээр сургалт явуулж, шинээр сонгогдсон хороодын Иргэдийн Нийтийн Хурлын дарга нарт ажлын үнэмлэхийг нь гардууллаа.

Хороодын Иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчдийн ээлжит зөвлөлдөх уулзалтыг хороодын Иргэдийн Нийтийн Хурал, Тэргүүлэгчдийн чиг үүрэг, Нутгийн удирдлага, Иргэний оролцоо сэдвээр Монголын нутгийн удирдлагын холбоотой хамтран зохион байгуулж тус уулзалтад 19 хорооны нийт 80 гаруй Иргэдийн Нийтийн Хурлын дарга, Тэргүүлэгчид оролцсон бөгөөд НӨУБ-ын ололт, өөрчлөлтүүд сэдвээр санал бодлоо солилцлоо.

Түүнчлэн хороодын Иргэдийн Нийтийн Хурлын үйл ажиллагааг сурталчилах “Нээлттэй өдөрлөг”-ийг 3, 5, 6, 10, 13, 14 дүгээр хороодод амжилттай зохион байгуулж, иргэдэд үйл ажиллагаагаа сурталчилан, туршлага, ололт амжилтынхаа талаар болон цаашид хийж хэрэгжүүлэх ажлынхаа талаар товч танилцуулга хийж, ажлын туршлага, шинэлэг санаа, бүтээлч ажлын үр дүнг хэлэлцэж, сайн туршлагыг хороодын үйл ажиллагаанд нэвтрүүлэх, хэрэгжүүлэх талаар санал солилцсон юм.

Аливаа ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх ажлын гол үндэс нь иргэдийг мэдээллээр хангах явдал учраас хороодын Иргэний танхим иргэдийн хөгжлийн төв байх ёстой. Иргэд мэдлэгтэй мэдээлэлтэй байж идэвхтэй, чадвартай оролцоог бий болгож чадна.

Тиймээс “Иргэний танхим”-аар хийгдэх үйл ажиллагааны төлөвлөгөөг тухайн хороодын онцлогт тохируулж, хороодын Иргэдийн Нийтийн Хурлын дарга, Засаг дарга нарын саналыг тусган боловруулан батлуулж, хэрэгжилтийг жигд ханган ажиллахаас гадна Иргэний танхимаар үйлчлүүлж буй иргэдийн тоон мэдээ, өргөдөл, гомдол, санал хүсэлт, цахим хаягт хийсэн тандалтын судалгааг сар

тутамд гаргуулан авч, танхимаар дамжуулан зохион байгуулж буй үйл ажиллагаандаа дүн шинжилгээ хийн, үр дүнг тооцон ажиллаж байна.

Түүнчлэн Иргэний танхимын үйлчилгээг иргэн бүрт жигд хүргэх зорилгоор иргэний танхимын тогтмол үйл ажиллагааны хуваарийг батлан эмэгтэйчүүд, ахмад настан, залуучууд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, иргэдийн бүлэг, хийн дасгал, нийтийн бүжиг, сургалт, мэдээллийн цаг гарган иргэдэд Төрийн үйлчилгээг жигд хүргэн ажиллаж байна.

Иргэний танхимаар зохион байгуулсан үйл ажиллагааг олон нийтэд шуурхай сурталчилах зорилгоор нийт 2363 удаа цагаан мэдээ бэлтгэн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, иргэний танхимуудын нүүр хуудсанд байршуулсан ба давхардсан тоогоор 100851 иргэн хандаж мэдээ, мэдээлэл авсан байна.

Иргэний танхимаар зохион байгуулсан ажлуудаас дурдвал:

**Уулзалт, хэлэлцүүлгийн чиглэлээр:** “Жаргалтай гэр бүл”, “Хотын иргэн-хотын соёл”, “Хамтдаа хөгжье”, “Гамшиг осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх”, “Ногоон дүүрэг”, “Гэртээ харих зам”, “Хүчирхийллийг таслан зогсооё”, “Эрүүл аюулгүй орчинд амьдарцгаая”, Улаанбаатар гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл-1 хүрээнд “Сэлбэ дэд бүс баригдах дулааны станцын нөлөөллийн бүсэд оршин суугаа иргэдийн санал асуулга” “Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаарх хэлэлцүүлэг”, хороодын Засаг даргыг сонгох, Засаг дарга, Өрхийн эмнэлэг, Цагдаагийн хэсгийн 2016 оны тайланг тайлагнаж үнэлэлт, дүгнэлт өгөх болон Иргэдийн Нийтийн Хурлын дарга, Тэргүүлэгчдийг сонгох Иргэдийн нийтийн хурал, сар шинийн баярын хүндэтгэлийн арга хэмжээ, “Иргэдээ сонсьё аян”, Иргэдийн Нийтийн Хурал, Иргэний танхимын нээлттэй хаалганы өдөрлөг, Аюулгүй орчин таны оролцоо өдөрлөг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх багийн хамтарсан зөвлөлдөх уулзалт, Иргэний танхимын дэргэдэх “Залуучуудын клуб”-ын уулзалт, Гудамж байрны нийтийн эргүүлүүдийн мэдээ, мэдээлэл солилцох уулзалт, СӨХ-ны дарга нартай уулзах уулзалт, залуучуудын “Бид хамтдаа”, “Төлөөлөгч сонгогдсон тойргийн иргэдтэй хийх уулзалт, “Мөрдөстэй залуу нас” “Дархан бэр” зэрэг нийт 180 гаруй удаагийн /давхардсан тоогоор/ уулзалт, хэлэлцүүлгийг тус тус зохион байгууллаа.

Тайлант хугацаанд дээрх уулзалт, хэлэлцүүлэгт нийт 22840 иргэн хамрагдсан байна.

• **Сургалт, мэдээллийн чиглэлээр:** Сургалт, мэдээллэл зохион байгуулсаныг агуулга, ач холбогдолоор нь ангилан үзвэл:

• **Эрүүл мэндийн чиглэлээр:** “Нялх хүүхдийг ойлгох нь”, “Хүүхдийн түлэгдэлт-Эцэг эхийн хариуцлага”, “Томуу томуу туст өвчнөөс сэргийлье”, “Жирэмсэн эмэгтэйн сэтгэл зүй”, “Эмийг зөв зохистой хэрэглэе”, “Түлэгдэлтийн үед авах арга хэмжээ”, “Чих хамар хоолойн анхан шатны үзлэг”, элэгний В,С вирус, хлострин, биеийн жин, ус, калицийн хэмжээ тодорхойлох, ЭХО, “Эрүүл мэнд-эрхэм баян”, “Урт насалж, удаан жаргая”, сүрьеэгийн эсрэг үнэ төлбөргүй оношилгоо, “Хавдарын үндэсний когорт судалгаа”, ЭМЖЖ-чих хамар хоолой үзлэг, “Эрүүл амьдралын нууц”, “Сүрьеэгүй Монголын төлөө хамтдаа төсөл, “Сайн санааны

туслагч бэлтгэх”, “Бэлгийн амьдрал”, “Хорт зуршлаас татгалзъя”, “Ажлын байрны дасгал, хөдөлгөөн”, “Хорт зуршил бидний ирээдүй биш”, “Элэгний архаг үрэвсэл”, “Нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Жирэмсэн эхийн асаргаа, сувилгаа”, “Эрүүл байхын үндэс-Эрүүл зөв хооллолт”, “Өрхийн бэлэн байдал”, “Архины хор хөнөөл”, “Дэлгэцийн донтолт түүний хор уршиг, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх”, “Эрүүл орчинд амьдаръя”, “Эрүүл эхээс-Эрүүл удам”, “Хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлье”, “Сүрьеэ өвчин”, “Сайн хяналтаас-эрүүл эх-эрүүл хүүхэд”, “Хавдар түүнээс хэрхэн урьдчилан сэрийглэх вэ?”, “Нойргүйдэл болон зөв хооллолт”, “Нуруу нугасны өвчлөлөөс урьдчилан сэргийлэх нь”, “Хөхөөр хоололтын ашиг тус”, “Нярай хүүхдийг асран хамгаалах арга зүй”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөгжүүлэх”, “Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх”, “Нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Ахмад настны тухай хууль”, “Эрүүл хүүхэд-эрүүл дүүрэг”, “Эрүүл хөдөлгөөн-Идэвхтэй амьдрал”, “Ариун цэврийн байгууламжаа сайжруулъя”, “Антибиотекийн хэрэглээнээс тагалзаж, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх нь”, “Шээс задгайрах өвчнөөс сэргийлэх нь”, “Хүнсний аюулгүй байдал, гурилан бүтээгдэхүүнийг зөв сонгож хэрэглэх нь”, “Өрхийн Эрүүл мэндийн төвийн сувилагчдыг чадавхжуулах нь”, энэ чиглэлээр 45 сургалт зохион байгуулагдсан.

- **Хууль, эрх зүйн чиглэлээр:** “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль”, “Нийслэлийн хотын албан татварын хууль”, “Агаар хөрс, хог хаягдалын тухай хууль”, “Хот тохижилт цэвэрлэгээний талаар байгууллага ААН-үүдэд мөрдөх журам”, “Ахуйн гал түймрээс сэргийлэх, шөнийн хэрэглээний цахилгааны төлбөрийг тэглэсэн тухай”, “АЗ сертификат олгох”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нь”, “Хүчирхийлэлд өртөж болзошгүй хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрх зүй”, “Гэр бүлийн хүчирхийлэл”, “Хүүхдийн эрх, хүүхдийн эсрэг хүчирхийлэл”, “Гамшгийн эрсдэлийг даван туулах чадвар”, “Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах дэд бүс”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн байдал”, “Иргэдийн дуу хоолой ба түүний үр нөлөө”, “Нийгмийн даатгалын тухай хууль сурталчилах, үйлчилгээ үзүүлэх өдөрлөг”, “Өрхийн жагсаалт газрын зураг бэлтгэх” сургалт, “Е баримт болон нэгдсэн системийн тухай”, Эрхзүйн боловсрол-Иргэний хөгжил”, “Иргэн танд зөрчлийн тухай хуулиас”, “Гэмт хэргээс хамтдаа сэргийлье”, “Хүчирхийллийн эсрэг хамтдаа”, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”, “Гэмт хэргээс хамтдаа сэргийлье”, “Хууль зүйн зөвлөгөө, үйлчилгээ”, “Гэр бүлийн хүчирхийллээс урьчлан сэргийлэх, түүнийг илрүүлэх нь”, “Авлига гэж юу бэ”, “Хүүхэд хамгааллын тухай хууль”, “Цахим гадуурхалт”, “Үе тэнгийн дарамт, шахалт”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь”, “Цахим орчин дахь гэмт хэргийн шинж чанар”, “Хог хаягдлын тухай хууль”, “Хүүхдийн эрхийн конвенц”, “Үнэт цаасны тухай хууль”, “Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлье”, “Зөрчлийн тухай хууль”, “Гудамж байрны хаягжилтийг жигдэрүүлэх нь”, “Эрх зүйн шинэчлэл Иргэний боловсрол”, “Хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэхэд эцэг, эхчүүдийг хяналтыг сайжруулах”, “Архидан согтууруулахтай тэмцэх тухай хууль”, энэ чиглэлээр 41 сургалт зохион байгуулагдсан.

- **Хувь хүний хөгжлийн чиглэлээр:** “Харилцааны ур чадварыг хөгжүүлэх нь сургалт”, “Гарц”, “Гэрээр айлчлагч”, “Өрхийн санхүүгийн сургалт”, “Би хэн бэ”,

“Бэлгээ өөрсдөө бэлдье”, “Гэр бүлийн баяр хөөр”, “Хүүхдээ эерэг аргаар хүмүүжүүлэх, сайн эцэг эх болох нь”, “Сайн эцэг эх болох нь- Хүүхдээ эерэг аргаар харилцах нь”, “Аз жаргалтай-Залуу нас”, “Хүүхэд бидний ирээдүй”, “Хүүхэд хамгааллын сургалт”, “Эерэг аргаар хүүхдээ хүмүүжүүлэе”, “Миний бизнесийн амжилт”, “Өөрийгөө нээх нь”, “Угийн бичиг”, “Харилцаа, харилцааны ур чадвар”, “Зан чанар”, “Стресс менежмент, хандлагын хүч, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэрэлт ирээдүй”, “Стрессийг тайлах хүчин зүйл”, “Төсөл хэрхэн бичих бэ?”, “Хүүхдийн хүмүүжлийн эерэг аргууд”, “Бизнес сэтгэлгээг хөгжүүлэх нь”, “Өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах”, “Өдөр тутам хэрэглэх хүмүүжлийн эерэг арга”, “Гэр бүлийн үнэ цэнэ”, “Хүүхдийн хүмүүжил эцэг, эхээс”, “Ажилд орох иргэдэд зориулсан сургалт”, “Англи хэлийг анхнаас нь”, “Аж ахуй эрхлэлт, түүнийг хөгжүүлэх нь”, “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэрэлт ирээдүй”, “Залуучуудын хөгжлийн эхлэл”, “Хамтдаа сурцгаая”, “Зөв гэр бүлээс зөв хүүхэд”, “Гэр бүлийн харилцаа ба хүчирхийлийг илрүүлэх нь” чиглэлээр 37 сургалт зохион байгуулагдсан.

- **Байгаль, орчин экологийн чиглэлээр:** “Эко ногоон орчин”, “Өрхийн бэлэн байдал”, “Дулаан дамжуулах эко төхөөрөмж”, “Гамшгаас хамгаалах нь”, “Ойд болсон явдал”, “Үерийн далан, сувагт бохир ус хог хаягдал”, “Эвт шаазгай буга барина эко сургалт”, “Хийн төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны зааварчилгаа”, “Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэе”, “Дулаалгын дулаан хуримтлуулах, халах төхөөрөмжийн зөв хэрэглээ”, “Орчны бохирдол-Иргэдийн хяналт”, “Гал түймэр ахуйн ослоос урьдчилан сэргийлэх, шаардлагатай үед авах арга хэмжээ”, “Ногоо тариалах иргэдэд хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгаа”, “Гэр болон амины орон сууцны дулаан алдагдалтыг бууруулах зөвлөмж”, чиглэлээр 16 сургалт зохион байгуулагдаж иргэдэд олон талын мэдлэг, мэдээлэл хүргэж ажиллалаа.

Тайлант хугацаанд нийт 139 удаагийн /давхардсан тоогоор/ сургалтуудыг тус тус зохион байгуулж, 29776 иргэн хамрууллаа.

**Тогтмол үйл ажиллагааны чиглэлээр:** Иргэний танхимын үйл ажиллагааг тогтмолжуулах зорилгоор тогтмол үйл ажиллагааны хуваарийг батлан, долоо хоног бүр нийтийн бүжиг, хийн дасгалын цаг, архины эсрэг идэвхтэй амьдрал клуб, сонин унших цаг, бясалгалын цаг, бүлгийн цаг, гудамж байрны нийтийн эргүүлийн цаг, ахмадын цаг, эмэгтэйчүүдийн цаг, илтгэх урлаг, мэтгэлцээний цаг, гар урлалын дугуйлан, шатрын сургалт, ширээний теннис, гитарын дугуйлан, хууль зүйн зөвлөгөө үйлчилгээний цаг зэрэг сургалт, үйл ажиллагааг тогтмол зохион байгуулсанаар давхардсан тоогоор нийт дүүргийн 6895 иргэн хамрагдаж үйлчлүүлсэн байна.

Тайлангийн хугацаанд хороодын Иргэний танхимаар давхардсан тоогоор нийт 59511 иргэн үйлчлүүлж, мэдээ, мэдээлэл авсан байна.

## **ДӨРӨВ. “ЗОХИОН БАЙГУУЛАЛТ-ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА”**

Хурлын Ажлын алба нь Хурал, Тэргүүлэгчдийн бодлого зорилтын хэрэгжилтийг зохион байгуулах, Хурлын хороодын хуралдааны бэлтгэл ажил,

хуралдаанаас гарах шийдвэрийн төсөл боловсруулан батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих, Хурлын Төлөөлөгчдийн хуралдаа ажиллах нөхцөл бололцоог хангах, техник, зохион байгуулалт, арга зүйн туслалцаа үзүүлэх, Хурал, Тэргүүлэгчдээс зохион байгуулсан ажлыг иргэд, олон нийтэд сурталчилах, хурал, цуглаан, төвлөрсөн болон хяналт шалгалтын бусад арга хэмжээг зохион байгуулах, Хурлын байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналт, төсөв санхүү зэрэг хурлын байгууллагын хэвийн үйл ажиллагааг чиг үүргийн дагуу ханган ажиллалаа.

Хурлын Ажлын албаны албан хаагчдын ажлын байрны чиг үүрэг, ажил үүргийн хуваарийн давхардлыг арилгах, шинэчлэх зорилгоор Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 01 дүгээр тогтоолоор Хурлын Ажлын албаны бүтэц орон тоог шинэчлэн баталсан бөгөөд одоогоор Хурлын Ажлын алба, Хурал дахь намын бүлгүүд нийт 43 орон тоотой ажиллаж байна.

Шинэчилсэн бүтцийн дагуу Хурлын Ажлын албаны албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарийг шинэчлэн боловсруулж, Төрийн захиргааны болон Улс Төрийн, Төрийн үйлчилгээний албан хаагчидтай үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээ байгуулан хэрэгжилт, үр дүнг Хурал, Тэргүүлэгчдэд тайлагнан ажиллаж байна.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба 2017 онд хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл бүхий 5 бүлэг 70 ажил үйлчилгээг зохион байгуулахаар төлөвлөснөөс 67 ажлыг бүрэн хэрэгжүүлж, биелэлт 95,7 хувьтай байна.

Тайлангийн хугацаанд Хурлын Ажлын албаны үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар Хурлын дарга 32 захирамж баталснаас хүний нөөцийн чиглэлээр-8, хяналт шалгалтын чиглэлээр-7, зохион байгуулалтын чиглэлээр-13, бусад чиглэлээр 4 захирамж баталсан байна.

Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Хурлын Ажлын албаны даргаас тайлангийн хугацаанд хүний нөөц болон төсөв, санхүүтэй холбоотой асуудлаар 270 тушаал шийдвэрийг батлан, Тэргүүлэгчдээс баталсан төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулахад шаардагдах төсвийг зориулалтын дагуу захиран зарцуулж, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг цаг хугацаанд нь төсвийн ерөнхийлөн захирагч болон холбогдох байгууллагуудад тайлагнан ажиллалаа.

Хурлын байгууллагын тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангах, ажлын бүтээмжийг дээшлүүлэх, ажилтан, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх хүрээнд “Төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээ байгуулах, түүнийг үнэлэх, дүгнэх журам”, “Нийтийн сонсгол хэлэлцүүлэг хэрхэн зохион байгуулах вэ”, “Нийтийн сонсголын тухай хууль” сэдвийн хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн харьяа Удирдлагын академи, Төрийн албаны зөвлөлтэй тус тус хамтарсан сургалт зохион байгуулж, УИХ-ын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, ШХА-ын хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн нэгжээс иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын

нэгдсэн портал [khural.mn](http://khural.mn) цахим хуудасны хөтлөгч хөгжүүлэгч-админы сургалтад хамрагдлаа.

Хурлын Ажлын алба 12 бүлэг, 100 зүйл, 88 заалт бүхий хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулж, Хурлын Тэргүүлэгчдээр батлуулсан бөгөөд уг журмын хүрээнд 43 албан хаагчдыг эрүүл мэндийн иж бүрэн үзлэг, оношлогоонд хамруулж, 9 иргэнийг Төрийн албанд шинээр томилж, 7 албан хаагчийг өөрийнх нь хүсэлтээр чөлөөлж, 6 албан хаагчийг Төрийн албанаас түр чөлөөлж, 3 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан байна.

Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу Хурлын Ажлын албаны 12 албан хаагчдад, Хурлын дүрэмд заасны дагуу Хурлын Төлөөлөгч 8 төлөөлөгчдөд, Хороодын Иргэдийн Нийтийн Хурлын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх журмын хүрээнд 3 хорооны ИНХ-ын дарга нарт тус тус нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж үзүүллээ.

Хурлын Ажлын албаны ажилтан, албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах хүрээнд Хурлын Ажлын алба, Хурал дахь намын бүлгүүдэд хуваарилсан өрөө, тасалгааны урсгал засварын ажлыг холбогдох журмын дагуу мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, хэвийн ажиллах нөхцөлийг ханган ажиллалаа.

Тайлант хугацаанд Хурлын Ажлын албанд ирүүлсэн санхүү, бүртгэлийн болон архив албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллагын удирдамж, төлөвлөгөөний дагуу бэлтгэл ажлыг хангаж, шалгалтын үр дүнд хангалттай үнэлгээ дүгнэлт авч ажиллалаа. Тэдгээрээс дурдвал:

Нийслэлийн аудитын газраас 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баримт, холбогдох хууль, Сангийн сайдын баталсан заавар, журам, улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв илэрхийлэгдсэн гэж дүгнэн “Зөрчилгүй, санал, дүгнэлт” үнэлгээ авч ажилласан байна.

Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2017 оны А/122 дугаар тушаал, “Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээний 2016 оны биелэлтийг дүгнэх удирдамж”-ийн дагуу тус гэрээг дүгнэх ажлын хэсэг байгууллагын хөрөнгийн хөдөлгөөн, бүртгэл, ашиглалт, хамгаалалт, санхүүгийн тайлан, төлбөр, тооцоо, холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн өмчийн харилцааны газрын тушаал, шийдвэрийн биелэлтэд хяналт шалгалт хийсэн бөгөөд бүрэн хангалттай үнэлгээ авлаа.

Нийслэлийн Архивын газрын даргын баталсан “Нийслэлийн байгууллагуудын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хийх иж бүрэн хяналт шалгалтын удирдамж”-ийн хүрээнд байгуулагдсан ажлын хэсэг Хурлын байгууллагын 2015-2016 оны архивын баримт, зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийн стандарт, Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын хэрэгжилт, баримт бичгийн боловсруулалт, лавлагаа, мэдээлэл, архивын ажлын




удирдлага, зохион байгуулалт, тоо бүртгэл, баяжилт, шинэчлэлтэд хяналт шалгалт хийсэн бөгөөд тус шалгалтын хангалттай үнэлгээ авч ажиллалаа.

Нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын 2016 оны мэдүүлгийг цахимаар хүлээн авсан бөгөөд Хурлын Төлөөлөгч, Хурлын Ажлын албаны ажилтан, дүүрэг, хороодын Засаг дарга нийт 45 албан тушаалтныг бүртгэн, хуулийн хугацаанд нь тайлан мэдээг хүргүүлж ажиллалаа.

Хурлын Ажлын албанаас батлагдан гарч буй захирамжлалын болон зохион байгуулалт, мэдээлэл лавлагааны баримт бичгүүдийг архив, албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу үйлдэж, тайлант хугацаанд байгууллага, иргэдээс <https://edoc.ub.gov.mn/> цахим сайтаар хариутай 45, хариугүй 189 нийт 234 албан бичиг хүлээн авснаас Дээд газраас 21, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, хэрэгжүүлэгч агентлагуудаас 33, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссоос 3, ИТХ дахь намын бүлгүүд, хурлын хороодоос 10, дүүргийн Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтэс албадаас 122, дүүргийн сургууль, цэцэрлэгээс 22, Хууль хяналтын байгууллагаас 9, Төрийн бус болон олон нийтийн байгууллагаас 6, Бусад 8 албан бичиг тус бүр ирүүлсэн байна.

Ирсэн бичгийг ангилбал:




Ирсэн бичгийн шийдвэрлэлт:



Ажил хэргийн шугамаар дээд шатны болон бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд нийт 406 албан бичиг хүргүүлснээс: Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Хэрэгжүүлэгч агентлагуудад 61, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комисст 4, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дахь намын бүлгүүд, хурлын хороодод 17, дүүргийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтэс албадад 174, Гадаад улс орнуудад 29, Төрийн бус болон олон нийтийн байгууллагад 36, Тодорхойлолт- 60 тус тус хүргүүлсэн байна.


Явсан бичгийг ангилбал:



Тайлангийн хугацаанд Хурал, Тэргүүлэгчид түүний Ажлын албанд Нийслэлийн нэгдсэн өргөдөл, гомдлын [www.smartcity.mn](http://www.smartcity.mn) цахим сайтаар ирүүлсэн 20 өргөдлийг бүртгэн авснаас 6 өргөдлийг Хурлын Ажлын алба шийдвэрлэж, 14 өргөдлийг Засаг даргын Тамгын газар түүний харьяа хэлтэс албадад цахимаар болон албан тоотоор шилжүүлж шийдвэрлүүлээ.

Ирүүлсэн өргөдөл, гомдлыг ангилвал:

Санхүүгийн тусламж хүссэн – 7, Нийгмийн халамж,- 6, Төрийн үйлчилгээ хүссэн-1, дэд бүтэц, газартай холбоотой-1, гомдол-2, хүсэлт-3 байна.



Тайлант хугацаанд Хурлын дарга албан ажлаар нийт 120 иргэнийг хүлээн авч, уулзсан бөгөөд иргэдээс тавьсан санал, хүсэлт, асуудлуудыг тухай бүрт шийдвэрлэн ажилласан байна.

Байгууллагын 2017 оны архивын ажлын төлөвлөгөө, хуваарь, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг батлуулж, ББНШК-г 4 удаа хуралдуулан, цахим болон цаасан архиваас Хурлын Ажлын алба, иргэд, аж ахуйн нэгжид 20 лавлагаа гарган үйлчилсэн байна.

Төрийн цол, одон медалиар шагнуулахаар байгууллага, хамт олноосоо тодорхойлогдож ирсэн Чингэлтэй дүүргийн харьяат 920 иргэний шагналын тодорхойлолт, Алдарт эх 1, 2 дугаар зэргийн одонгийн болзол хангасан 370 эхийн материалыг тус тус Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд дэмжиж уламжилсан байна.

Нутаг дэвсгэрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс дүүрэг хөгжүүлэх үйлсэд бодит хувь нэмэр оруулан хариуцсан ажилдаа амжилт гарган ажиллаж байгаа нийт 336 иргэнийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дээд шагнал “Чандмань одон”-оор, 119 иргэнийг Хурлын “Хүндэт өргөмжлөл”-өөр тус тус шагнаж урамшуулсан байна.

Шашин сүм хийдтэй харилцах чиглэлээр дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй нийт 36 шашны байгууллагаас 11 нь буддын шашин, 25 нь христийн шашны үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд дээрх байгууллагаас 14 хүсэлт ирүүлсэнээс үйл ажиллагаа эрхлэх хугацаа сунгуулах хүсэлт ирүүлсэн 10 байгууллага, шинээр үүсгэн байгуулах тухай хүсэлт ирүүлсэн 4 байгууллагын хүсэлтийг тус тус хянан үзэж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд дэмжиж уламжиллаа.

**ТАВ. “ХУРЛЫН ГАДААД, ДОТООД ХАРИЛЦАА, ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ”**

Хурлын Тэргүүлэгчид, Ажлын албанаас Хурлын байгууллагын үйл ажиллагааны талаар хэвлэл, мэдээлэл, цахим хуудас, олон нийтийн сүлжээ, мэдээллийн самбараар дамжуулан олон нийтэд бодитой, шуурхай, өргөн мэдээлэл өгч ажиллаж байна.

Дүүргийн Төр захиргааны байгууллагын нээлттэй ил тод байдлыг ханган, Төрийн бодлого шийдвэр, хэрэгжилт, цаг үеийн мэдээ мэдээлэл, хурал Тэргүүлэгчдээс баталсан тогтоол, холбогдох хууль тогтоомжийн булан, зохион байгуулсан болон зохион байгуулах аливаа үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээлэл, хурлын хуралдаан болон хурлын хороодын хуралдааны тойм, Хурлын Ажлын албаны үйл ажиллагааны талаарх мэдээллийг [www.chingelteicouncil.mn](http://www.chingelteicouncil.mn), [www.khural.mn](http://www.khural.mn) цахим хуудас, facebook, twitter зэрэг олон нийтийн сүлжээгээр дамжуулан иргэд, олон нийтэд шуурхай хүргэж ажиллалаа.

Тайлангийн хугацаанд [www.chingelteicouncil.mn](http://www.chingelteicouncil.mn) цахим хуудсанд давхардсан тоогоор [www.chingeltei.ub.khural.mn](http://www.chingeltei.ub.khural.mn) 144628, цахим хуудсанд 165992 хэрэглэгч хандаж мэдээлэл авсан байна.

Нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны 375 жилийн ой, Монголын нутгийн удирдлагын холбооны 25 жилийн ойг угтаж хороодын Иргэдийн Нийтийн Хурлын үйл ажиллагааг сурталчилах зорилгоор МНУХ-оос эрхлэн гаргадаг “Нутгийн удирдлага” сэтгүүлд нүүр бүхий танилцуулга, ярилцлага, нийтлэлийн эх бэлтгэн хэвлүүллээ.

Шинээр сонгогдсон Хурлын Төлөөлөгч бүрт иргэд, байгууллагатай харилцах албан ёсны [/.....@chingelteicouncil.mn/](mailto:.....@chingelteicouncil.mn) хаягыг шинээр нээн өгсөн байна.

Нутгийн өөрөө удирдах байгууллагуудтай ажил төрлийн холбоо тогтоох, дүүргийн хөгжлийн бодлогын асуудлаар ижил төстэй байгууллагуудын ажлын туршлагыг судалж өөрийн ажилдаа нэвтрүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжихэд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2017 онд гадаад, дотоод харилцаагаа өргөжүүлэх зорилт тавьж, энэ чиглэлээр дараах ажлыг зохион байгуулсан юм. Үүнд:

Тайлангийн хугацаанд найрамдалт харилцаат бүхий БНХАУ-ын Манжуур, Эрээн хот, БНСУ-ын Сөүл хотын Соо дүүрэг, БНТУ-ын Истанбул хотын Пендик дүүргүүдтэй байнгын харилцаатай ажиллаж, 42 удаа захидал, цахим шуудангаар харилцсан байна.

Гадаад арга хэмжээний хөтөлбөрт Хурлын Тэргүүлэгч Л.Баярсайхан тэргүүтэй Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газрын 8 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Манжуур хотод, Хурлын Төлөөлөгч Д.Нэмэхбат тэргүүтэй 4 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хайлаар, Амгаланбаатар хотод, Тэргүүлэгч Б.Батхуяг тэргүүтэй 4 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг БНТУ-ын Анкара хотын Синжан дүүрэг, Анталия хотын Кемир дүүрэгт, Төлөөлөгч Д.Мөнхтөр тэргүүтэй 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг БНСУ-ын Сөүл хотын Сонгбук дүүрэгт тус тус ажлын айлчлал хийлээ.

Айлчлалын үр дүнд БНХАУ-ын Хойд бүсийн олон улсын шинжлэх ухаан, технологийн 14 дэх удаагийн үзэсгэлэнд Чингэлтэй дүүргийн жижиг дунд бизнес эрхлэгчдийг оролцуулах, Манжуур хотод “Чингэлтэйд үйлдвэрлэв төв”-ийг нээх талаар холбогдох албаны хүмүүстэй уулзалт яриа хэлэлцээрийг хийснээс гадна, БНСУ-ын Сөүл хотын Сунгпа дүүрэгт 9 дүгээр сард зохион байгуулагдах Олон Улсын хүүхдийн урлагийн наадамд дүүргийн Ардын урлагийн хүүхдийн хамтлагийг оролцуулах, БНТУ-ын Синжан хотын үйлдвэрлэлийн бүсийн сургалт үйлдвэрлэлийн төвд 4 төрлийн мэргэжлээр ажилтан бэлтгэхэд жил бүр 5-10 иргэнийг ТИКА олон улсын байгууллагаар дамжуулан сургах, Анталия хотын Кемир дүүрэгтэй аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах, санамж бичигт үзэглэх зэрэг яриа хэлэлцээрийг хийлээ.

Тайлант хугацаанд ОХУ-ын Улаан-Үд хотын Советский дүүргийн 1 дүгээр орлогч Франк Игорь Георгиевич тэргүүтэй зочид төлөөлөгчдийг Чингэлтэй дүүрэгт хүлээн авч, дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн багш солилцоо болон багш, сурагчдын Математикийн олон улсын уралдааны талаар харилцан санал солилцож Чингэлтэй дүүрэг-Советский дүүргийн хамтын ажиллагааны суурь эхлэлийг тавьснаас гадна Япон улсын Нагано мужийн Камина дүүргийн Төлөөлөгч Сакамото Норико тэргүүтэй төлөөлөгчдийг, БНСУ-ын Инчон хотын Соо дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Шим Ү Чан тэргүүтэй төлөөлөгчдийг тус тус Чингэлтэй дүүрэгт хүлээн авч, сурагч солилцоо, боловсрол, соёл, хот тохижилт, бүтээн байгуулалтын салбарт хамтран ажиллахаар харилцан тохиролцлоо.

Чингэлтэй дүүрэг үүсэн байгуулагдсаны түүхт 25 жилийн ойн баярын арга хэмжээнд гадаад харилцаа, хамтын ажиллагаа бүхий БНХАУ-ын ӨМӨЗО-ны Манжуур хотын Ардын Их Хурлын дарга Го Цзин Мин тэргүүтэй 6 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчдийг, ОХУ-ын Бүгд Найрамдах Саха улсын Хангаласский дүүргийн Хурлын дарга Борис Петрович тэргүүтэй 5 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчдийг Чингэлтэй дүүрэгт урьж, ойн баярын арга хэмжээнд оролцуулах, ажлын айлчлалыг зохион байгууллаа.

Дотоод томилолт, арга хэмжээний хүрээнд Архангай, Баянхонгор, Увс, Өвөрхангай, Төв, Хэнтий, Өмнөговь, Дорноговь, Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хамтран ажиллах саналыг хүргүүлж, Дорноговь, Баянхонгор, Увс, Архангай аймгийн Чулуут сум, Хөвсгөл аймгийн Чандмань Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөллийг Чингэлтэй дүүрэгт хүлээн авч, харилцан туршлага солилцлоо.

### **ДОЛОО. “ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА”**

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал 2017 онд нутаг дэвсгэрийн хэмжээнд нийгмийн дэг журмыг хангуулах, хүн амын эрүүл, аюулгүй орчинд амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн цогц бодлогыг хэрэгжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд бүх нийтийн оролцоог бий болгох, хамтран ажиллах замаар камерын хяналттай, гэмт хэрэг, зөрчилгүй хороо, дүүрэг болгох зорилт дэвшүүлэн ажиллалаа.

Дээрх зорилтын хүрээнд 8 зорилт бүхий Иргэний оролцоотой-хяналттай орчин” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжилтийг дүүргийн Засаг даргын Тамгын газар, хууль хяналтын байгууллага, иргэдтэй хамтран хэрэгжүүлэн ажиллалаа.

Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл 2017 онд нутаг дэвсгэрийн хэмжээнд гарч байгаа гэмт хэрэг, зөрчлийн тоог бууруулах, шалтгаан нөхцлийг арилгахад онцгой анхаарч, 5 бүлэг, 55 ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөснөөс тайлант хугацаанд 50 ажил бүрэн хэрэгжиж биелэлт 90,9 хувьтай байна.

Тайлант хугацаанд Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл нийт 20 удаа хуралдаж 55 тогтоол, шийдвэрийг баталж, хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж ажиллалаа.

Дүүргийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх, Төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх хүрээнд хороо бүрт Засаг дарга, ИНХ-ын дарга, Нийгмийн ажилтан, Иргэний танхимын ажилтан, Хэсгийн байцаагчдаас бүрдсэн урьдчилан сэргийлэх багийг байгуулж, тэдгээрийн ажиллах журмыг боловсруулан, Хурлын Тэргүүлэгчдээр батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийг татан оролцуулах, иргэдийн сайн дурын үйл ажиллагааг дэмжих хүрээнд гудамж, байр бүрт ажиллаж буй нийтийн эргүүлүүдийн ажилтай танилцах, санал хүсэлтийг сонсох уулзалтыг зохион байгуулж, урамшууллын хэмжээг сар бүр 25000 төгрөг болгон нэмэгдүүлж, таних тэмдэг бүхий ажлын үнэмлэх, хантааз, малгайг шинэчлэн хүлээлгэн өгч, “Иргэдийн оролцоотой хяналттай орчин” сэдэвт нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар өдөр тутамд ханган ажиллаж байна.

Одоогоор дүүргийн хэмжээнд 728 иргэн гудамж, байрны нийтийн эргүүлээр, 23 иргэн хэв журмын урамшилт эргүүлээр тус тус ажиллаж байна.

Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл нь Гэмт хэрэг, хэв журмын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөлийг судлах, таслан зогсоох арга хэмжээний чиглэлийг тогтоох, нийгмийн хэв журмыг хангуулах, иргэдийн амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгийг сахин хамгаалах, иргэдийн амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах олон талт арга хэмжээг зохион байгуулсаар ирсэн билээ.

Энэхүү ажлын хүрээнд урьдчилан сэргийлэх багийн үйл ажиллагааг чадавхжуулах, санал санаачилгыг дэмжих хүрээнд “Амар тайван амьдралын төлөө хамтдаа” нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулж, тус зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжийг зурагт хуудас болгон хэвлүүлж, дүүргийн иргэд, айл өрх, аж ахуй нэгж, албан байгууллагад сурталчилах ажлыг зохион байгуулснаас гадна Хороодын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг удирдан зохион байгуулах баг, гудамж,

байрны нийтийн эргүүл, хэв журмын урамшилтай эргүүлийн нэгдсэн сургалтыг 2 удаа зохион байгуулж, хууль эрх зүйн мэдлэг олголоо.

Авлигатай тэмцэхэд иргэд, олон нийтийн оролцоог бий болгох, Төрөөс хэрэгжүүлж буй аливаа арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажилд иргэдийн хөндлөнгийн хяналтыг бий болгох зорилгоор “Иргэдийн хяналтын зөвлөл”-ийн ажиллах журмыг батлан, журмын хүрээнд хороо бүрт 5 хүний бүрэлдэхүүнтэй зөвлөл байгуулагдан, нийт 95 хүнийг бүртгэлжүүлэн ажиллалаа.

Авлигын эсрэг хууль, Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд иргэдийн хяналтыг бий болгох зорилго бүхий байгуулагдсан авлигаас урьдчилан сэргийлэх “Олон нийтийн дэд зөвлөл”-ийн гишүүдтэй гэрээ байгуулж, хамтран ажиллаж байна.

Дүүргийн хэмжээнд Хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, ажлын үр нөлөөг дээшлүүлэх хүрээнд хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах дүүргийн дэд зөвлөлийг байгуулан ажиллаж байна.

Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн гаралтыг бууруулах хүрээнд 19 дүгээр хорооны зуслангийн чиглэлд тээврийн хэрэгслийн электрон хурд хэмжигч төхөөрөмж, мэдээллийн самбар, 16 дугаар хорооны 139 дүгээр бага сургуулийн зүүн талын төв замд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан авто замын хэвтээ, босоо тэмдэг тэмдэглэгээг байршуулснаас гадна авто замын түгжрэлийг багасгах, хяналтыг сайжруулах, зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, эзэн холбогдогчийг түргэн шуурхай илрүүлэх зорилгоор дүүргийн нутаг дэвсгэрт суурилуулсан хяналтын камеруудаас 102 ширхэг камерын сүлжээг Чингэлтэй дүүрэг дэх Замын цагдаагийн хэлтэстэй холбох ажлыг эхлүүлэн, ажлын 60 хувийн гүйцэтгэлийг хүлээн аваад байна. Түүнчлэн нийтийн эзэмшлийн гудамж талбайд үйлдэгдэх гэмт хэрэг зөрчлийг бууруулах иргэдийг аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 1-19 дүгээр хорооны гудамж талбайд 170 ширхэг хяналтын камерыг 497,452,052 төгрөгийн өртөгтэйгөөр суурилуулах ажлыг хийж гүйцэтгүүлэн хүлээн авч, дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт “Камерын хяналтын бүс” тэмдэгийг 45 цэгт байршууллаа.

Мөн замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох, хөдөлгөөнд аюулгүй оролцох дадал эзэмшүүлэх, зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийг сурталчилах ажлын хүрээнд Ерөнхий боловсролын 15 сургуулийн 96 сурагчдын дунд “Ногоон гэрэл-Цагаан шугам 2017” тэмцээнийг амжилттай зохион байгуулан, шагнаж урамшууллаа.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/37, А/38, А/39 тушаалыг товхимол болгон хэвлүүлж, дүүргийн Цагдаагийн 1,2 дугаар хэлтсээр дамжуулан иргэд, олон нийтэд хүргэж ажиллалаа.

Мөн дүүргийн Цагдаагийн 1,2 дугаар хэлтэс тус бүрт гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсөд, гэрч хохирогч, хүүхдийг түр хамгаалах өрөөг байгуулан, нийт 40 сая төгрөгийн үнэ бүхий тохижилтын ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэн, ашиглалтад хүлээн авч, Цагдаагийн 1,2 дугаар хэлтэст хүлээлгэн өглөө.

Дүүргийн цагдаа, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, орчин үеийн техник, технологи бүхий тоног төхөрөөмжөөр хангах, ажиллах нөхцөлийг сайжруулах хүрээнд Цагдаагийн 1 дүгээр хэлтэст нийт 11,9 сая төгрөгийн үнэ бүхий хяналтын камерын төвийн тоног төхөөрөмж, Цагдаагийн 2 дугаар хэлтэст 44 сая төгрөгийн үнэ бүхий хяналтын камерын төв, дотоод хяналтын камерын төв, уулзалтын шилэн өрөө, хурлын танхимын өрөөний тавилга, тоног төхөөрөмж, зуслангийн постын лед самбар, камер, дүүргийн прокурорын газарт 5 сая төгрөгийн үнэ бүхий лед дэлгэц, самбар нийт 61 сая төгрөгийн үнэ бүхий тавилга, тоног төхөөрөмжийг дүүргийн Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс, Прокурорын газрын өмчид тус тус хүлээлгэн өглөө.

Нутаг дэвсгэрийн төрийн өмчит болон хувийн хэвшлийн Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн орчин тойрны аюулгүй байдал, хайс хашлага, замын тэмдэг тэмдэглэгээ, гэрэлтүүлэг, гадна, дотор орчны камержуулалтын хэвийн үйл ажиллагаа, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж сургууль, цэцэрлэгийн орчны аюулгүй байдлын судалгаа гарган зохицуулах зөвлөлийн хуралд танилцуулан, дүүргийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжлүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчид түүний Ажлын алба 2017 онд дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлж, дүүргийн эдийн засаг, нийгмийн зорилтууд, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бүхий л талын дэмжлэг үзүүлж ажиллалаа.

Түүнчлэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч бүр Хурлын үйл ажиллагаанд идэвх санаачилгатай оролцож, дүүргийн нийгэм, эдийн засгийн зорилтыг жигд ханган биелүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсаныг талархан тэмдэглэж байна.

ХУРЛЫН АЖЛЫН АЛБА